



## МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2014 оны 11 сарын 10 өдөр

Дугаар A-178

Улаанбаатар хот

Г “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банкны (Монголбанк)-ны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А-122 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-д дараах заалтыг нэмсүгэй.

1.2.15 *“Амины орон сууц”* гэж аймаг, сумын батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, орон сууцны хотхон, хорооллын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу аймаг, сумдад баригдаж, эрх бүхий байгууллагын шийдвэрээр байнгын ашиглалтад орсон, дэд бүтэц (цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга)-ийн шийдэл бүхий орон сууцыг.

3.3.8 Амины орон сууцны хувьд газрыг өмчлөх, эзэмших эрх улсын бүртгэлд бүртгэгдсэн байх бөгөөд эзэмших эрх нь 20-иос дээш жилийн хугацаатай байх.

2. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн А-122 дугаар тушаалаар баталсан “Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журам”-ын дараах заалтыг дор дурдснаар өөрчилсүгэй.

3.1.6 Орон сууцны ипотекийн зээлийн барьцаа нь зээлдэгчийн энэ журмын дагуу авсан зээлээр худалдан авах шинэ орон сууц, ашиглагдаж байгаа хуучин орон сууц, амины орон сууц байх;


3.3 Дэд хөтөлбөрийн хүрээнд энэ журмын дагуу олгох орон сууцны ипотекийн зээлийн барьцаа нь дараах шаардлагыг хангасан байна:

3.3.1 Монгол Улсад байршилтай нийтийн болон амины орон сууц байх;  
3.3.2 Шинэ орон сууц, эсхүл ашиглагдаж байгаа хуучин орон сууц, эсхүл амины орон сууц байх;  
3.3.3 Нийтийн зориулалттай орон сууцны талбайн нийт хэмжээ “Орон сууцны барилгын доторх сууцны талбай тооцох аргачлал” MNS 6058:2009 стандартын дагуу тооцсоноор  $80\text{ m}^2$ -аас дээшгүй байх. Үүнд энэ журмын 5.3-т заасан урьдчилгаа төлбөрийн орон сууцны ипотекийн зээлийн барьцаа хамаарахгүй;

5.4.5 Нийтийн зориулалттай орон сууцны болон энэ журмын 1.2.15-д заасан амины орон сууцны ипотекийн зээлээс бусад ипотекийн зээлийг дахин санхүүжүүлэхгүй.

3. Энэ тушаалыг хэрэгжүүлж ажиллахыг Монголбанкны Мөнгөний бодлого, судалгааны газар (Д.Болдбаатар), бүх банкны гүйцэтгэх захиралд тус тус даалгасугай.

4. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Монголбанкны Хяналт шалгалтын газар (Д.Ганбат), аймгууд дахь Монголбанкны салбар, хэлтсийн захиралд тус тус үүрэг болгосугай.



ЕРӨНХИЙЛӨГЧ

Н.ЗОЛЖАРГАЛ